



**АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЭХ
ҮҮСВЭР, ЗЭЭЛИЙН БАТЛАН
ДААЛТЫН САНГИЙН БАТЛАН
ДААЛТТАЙ ТӨСЛИЙН ЗЭЭЛ**

Төслийн зорилго

Барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд бизнес эрхлэгчдэд бизнесээ өргөжүүлэх, шинэ төсөл хэрэгжүүлэх боломжийг олгох зорилготой бөгөөд харилцагч Та зээлээр үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж худалдан авах, эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх боломжтой.

Зээлийн нөхцөл

Хамрах хүрээ	Жилийн борлуулалтын орлого 2.5 тэрбум төгрөгөөс дээшгүй жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгж
Зээлийн хэмжээ	2.0 тэрбум төгрөг хүртэл
Зээлийн хүү /жилээр/	8.88%-12.34%
Зээлийн хугацаа	10 жил хүртэл
Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа	2 жил хүртэл
Зээлийн үйлчилгээний шимтгэл	0.3% (хамгийн багадаа 50,000 төгрөг)
ЗБДС-ийн батлан даалтын хэмжээ	30%-60% (Нэмэлт 20%-ийн эх үүсвэр)
ЗБДС-ийн батлан даалтын хураамж	50,000 төгрөг (1 удаа төлнө)
ЗБДС-ийн батлан даалтын шимтгэл	Зээлийн үлдэглийн батлан даасан дүнгийн 1%-иар тооцож жил бүр төлнө

Санхүүжүүлэх салбар

Монгол Улсын Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуульд заасан тодорхойлолтод нийцсэн ЖДҮҮЭ бөгөөд энэ тухай тодорхойлолт авсан аж ахуйн нэгжид олгоно.

Санхүүжүүлэхийг хориглосон салбар

- Албадан хөдөлмөр эрхлэлт эсхүл хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн аюултай эсхүл мөлжлөгийн хэлбэр бүхий үйлдвэрлэл, эсхүл үйл ажиллагаа;

- Тухайн улсын хууль буюу журам, эсхүл олон улсын конвенц болон гэрээ, эсхүл олон улсад зогсоосон болон хориглосон нөхцөлийг зөрчсөн гэж үзсэн үйл ажиллагаа, эсхүл ямар нэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх, эсхүл худалдах, үүнд (а) эмийн бүтээгдэхүүн, пестицид, болон гербицид, (б) озон задлагч бодис, (в) полихлорт бифенил болон бусад аюултай химийн бодис, (г) Зэрлэг Амьтан ба Ургамлын Аймгийн Ховордсон Зүйлийн Олон Улсын Хэмжээнд Худалдаалах Тухай Конвенцын дагуу зохицуулагддаг зэрлэг амьтан эсхүл зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүн, болон (д) хаягдал эсхүл үйлдвэрийн хаягдал хил дамнан худалдах;
- Галт зэвсэг болон цэрэг дайны зориулалттай хэрэгсэл үйлдвэрлэх эсхүл худалдах, үүнд хагас цэрэгжүүлсэн бараа материал хамаарна;
- Согтууруулах ундаа үйлдвэрлэх, эсхүл худалдах, үүнд шар айраг болон дарс хамаарахгүй;
- Тамхины үйлдвэрлэл, эсхүл худалдаа;
- Мөрийтэй тоглоом, казино болон ижил төстэй үйл ажиллагаа;
- Цацраг идэвхит бараа материал үйлдвэрлэх болон худалдах, үүнд цөмийн реактор болон түүний эд анги хамаарна;
- Задгай асбестэн ширхэгүүд үйлдвэрлэх, худалдах эсхүл ашиглах;
- Арилжааны зориулалтаар мод бэлтгэх үйл ажиллагаа, эсхүл мод бэлтгэх тоног төхөөрөмж худалдан авж халуун бүсийн чийглэг ой эсхүл хүний мөр гараагүй ойд ашиглах;
- Далайн болон эрэг хавийн загас агнуурын үйл ажиллагаа, үүнд том хэмжээний тэнгисийн хөвөгч тор болон нарийн тороор загас барих, ховордсон ба тусгай хамгаалалттай амьтанд хор хөнөөлтэй, болон далайн амьтны төрөл зүйл ба амьдралын орчинд хохирол учруулах ажиллагаа;
- Өөрийн үйл ажиллагаанд ашиглахгүй үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулах, эсхүл үл хөдлөх хөрөнгө худалдан авах тохиолдолд;
- ЖДҮ-ийн өөрийн үйл ажиллагаанд зориулж эзэмшихээс бусад арилжааны зориулттай үл хөдлөх хөрөнгө барьж байгуулах;
- Дэд бүтцийн барилгын материалтай холбогдох салбарууд;
- Олон айлын орон сууцны барилга угсралт;

- Уул уурхайн, эрдэс боловсруулалт болон олборлох бүхий л үйл ажиллагаа;
- Газрын тос эсхүл эрчим хүч импортлохтой холбогдох бизнес;
- Голчлон тансаг хэрэглээний бүтээгдэхүүн импортлодог бизнес;
- Томоохон аж ахуйн нэгжийн охин компани эсхүл харьяа ЖДҮ;
- Хаягдал бохир усыг цэвэрлэх үйл ажиллагаа;
- Ус хангамжийн үйл ажиллагаа.

Бүрдүүлэх бичиг баримт

- Зээлийн өргөдөл
- ЖДҮҮЭ-ээр бүртгүүлсэн тодорхойлолт
- Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм
- Байгууллагын үл хөдлөх хөрөнгийг барьцаанд тавихыг зөвшөөрсөн хувь нийлүүлэгчдийн зөвшөөрөл
- Байгууллагын удирдах ажилтны иргэний үнэмлэхний хуулбар, анкет
- Байгууллагын товч танилцуулга
- Хэрэгжүүлэх төслийн танилцуулга (загварыг банкны салбараас авна уу)
- Санхүүгийн тайлан (сүүлийн 1-2 жилийн)
- Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, лиценз (шаардлагатай тохиолдолд)
- Барьцаа хөрөнгийн гэрчилгээ, газар эзэмших гэрчилгээ (эх хувиар)
- Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой гэрээ хэлцлүүд
- Орлого, зардал, өглөг, авлага, санхүүжилтийг нотлох анхан шатны баримтууд
- Зээл хүсэгч байгууллага, хувь нийлүүлэгчдийн нэр дээр авсан үл хөдлөх хөрөнгө эзэмшлийн дэлгэрэнгүй лавлагаа
- Бусад шаардлагатай баримт бичгүүд



ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ:

Утас:	+976 1800-1977
И-мэйл:	info@tdbm.mn
Вэб хаяг:	www.tdbm.mn